

ИРГЭДЭЭС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД 2019 ОНД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

2019 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр



Улаанбаатар
хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн
дүнгийн талаар

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар


Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн удирдах албан тушаалтанд 2019 онд иргэд, байгууллагаас 14247 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1595 нэгжээр буюу 12.6 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 194 буюу 1.4 хувь нь санал хүсэлт, 13820 буюу 97.0 хувь нь өргөдөл, 233 буюу 1.6 хувь нь гомдол байна.



Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 1080 буюу 7.6 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 199 буюу 1.4 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1589 буюу 11.2 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2927 буюу 20.5 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 547 буюу 3.8 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 7905 буюу 55.5 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 14206 буюу 99.7 хувийг шийдвэрлэж, 41 буюу 0.3 хувь нь ажиллагаанд байна.



Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2019 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, алба хаагчдаас 566 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 224 нэгжээр буюу 28.4 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 377 буюу 66.6 хувь нь өргөдөл, 75 буюу 13.3 хувь нь гомдол, 114 буюу 20.1 хувь нь санал хүсэлт байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг үтгээр нь авч үзвэл: 36 буюу 6.4 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 17 буюу 3.0 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 54 буюу 9.5 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 11 буюу 1.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 41 буюу 7.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 407 буюу 71.9 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2019 онд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 115 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 57 буюу 49.6 хувь нь санал хүсэлт, 46 буюу 40.0 хувь нь гомдол, 2 буюу 1.7 хувь нь өргөдөл, 8 буюу 7.0 хувь нь талархал, 2 буюу 1.7 хувь нь шүүмжлэл байна.



Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, талархал, шүүмжлэлийн 96 буюу 85.5 хувийг шийдвэрлэсэн байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 72 буюу 62.6 хувийг хурдан, 24 буюу 20.9 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 19 гомдол, санал хүсэлтийг холбогдох алба, нэгжид судалж байна.


Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд энэ онд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 1589 өргөдөл, гомдол ирүүлж, 1965 алба хаагчийг холбогдуулан шалгажээ. Үүний 1554 буюу 79.1 хувийг офицер, 407 буюу 20.7 хувийг ахлагч, 4 буюу 0.2 хувийг энгийн алба хаагч эзэлж байна.


Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл:

231 буюу 14.5 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 260 буюу 16.3 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 15 буюу 0.9 хувь нь хэргийн хугацаа хэтрүүлсэн, 92 буюу 5.6 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 20 буюу 1.2 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 367 буюу 23.1 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 79 буюу 5.0 хувь нь бусдын эрх чөлөөнд халдсан, 229 буюу

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдол, санал хүсэлт



14.1 хувь нь ажлын хариуцлага алдсан, 41 буюу 2.4 хувь нь архидан согтуурсан, 18 буюу 1.1 хувь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 184 буюу 11.4 хувь нь Эрүүгийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, 3 буюу 0.1 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу олгосон, 1 буюу 0.06 хувь нь хувцасны болон бусад хангамж дутуу олгосон, 49 буюу 3.1 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.



Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлоос 1523 буюу 95.8 хувийг шийдвэрлэж, 66 буюу 4.1 хувийг шалгаж байгаа бөгөөд нийт шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын 1499 буюу 98.4 хувийг 30 хоногт, 24 буюу 1.6 хувийг 30-60 хоногт шийдвэрлэсэн ба хугацаа хэтрүүлсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл: Нийт өргөдөл, гомдлын 72 буюу 4.5 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, 603 буюу 37.9 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 900 буюу 56.6 хувь нь цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 31 буюу 1.9 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдсон боловч хуль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах хугацаа хэтэрсэн гэх үндэслэлээр хаасан байна.

ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС